

Санхүүгийн туслалцааны бодлогын энгийн хэл найруулгаар бичсэн хураангуй

НордШоор их сургуулийн эрүүл мэндийн систем (НордШоор гэх)-ээс гачигдалтай өвчтөнүүдэд санхүүгийн туслалцаа үзүүлэх бодлогыг баримталдаг. НордШоор Санхүүгийн Туслалцааны бодлогын (FAP-СТБ) шалгуур үзүүлэлтийн дагуу санхүүгийн туслалцаа авах шаардлагыг хангасан хувь хүнд үнэ төлбөргүйгээр, эсвэл хөнгөлсөн дүнгээр яаралтай тусламжийн болон эмнэлгийн шаардлагатай үйлчилгээг үзүүлнэ. СТБ-ын шалгуурыг хангасан өвчтөнүүд эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд даатгалд хамрагдсан өвчтөнүүдэд ерөнхийдөө ногдуулдаг дундаж дүнгээс (ДД) илүү дүнгээр төлбөр тооцогдохгүй.

Санхүүгийн туслалцаа авах эрх бүхий байдлыг тогтоохдоо орлого, гэр бүлийн гишүүдийн тоо, Холбооны Ядуурлын Түвшин (ХЯТ) зэрэгт суурилдаг. ХЯТ нь өрхийн ам бүлийн тооноос хамааран өөр байх ба жил бүр шинэчлэн тогтоогддог.

Доорх хүснэгтээр санхүүгийн туслалцаа авах эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлтийг хураангуйлан үзүүлэв. Санхүүгийн туслалцаа болон Үндэслэлтэй эрх бүхий байдлын шалгууруудын талаарх нэмэлт мэдээллийг СТБ-оос авч болно.

Санхүүгийн туслалцаа	Хэн авах боломжтой вэ	ХЯТ	Тодорхойлолт	Хэрхэн хүсэлт гаргах вэ
Үнэ төлбөргүй үйлчилгээ	Даатгалгүй болон даатгалтай өвчтөнүүд	0% - 200%	Үндэслэлтэй эрх бүхий байдал эсвэл ам бүлийн тоо ба орлогод суурилна (ХЯТ)	Үндэслэлтэй эрх бүхий байдлаа нотлон харуулах эсвэл хүсэлтийн маягт бөглөх
Ялгавартай хэмжээгээр хөнгөлөлт эдлэх	Даатгалгүй болон даатгалтай өвчтөнүүд	201% - 400%	Ам бүлийн тоо ба орлогод суурилна (ХЯТ)	Хүсэлтийн маягт бөглөх
Ялгавартай хэмжээгээр хөнгөлөлт эдлэх	Зөвхөн даатгалгүй өвчтөнүүд	401% - 600%	Ам бүлийн тоо ба орлогод суурилна (ХЯТ)	Хүсэлтийн маягт бөглөх

Санхүүгийн туслалцааны бичиг баримтуудыг (бодлого, хураангуй, хүсэлтийн маягт гэх мэт) НордШоорын вэбсайтаас www.northshore.org/about-us/billing/financial-assistance эсвэл www.swedishcovenant.org/for-patients-and-visitors/pay-your-bill/financial-assistance эсвэл www.nch.org/billing-insurance/financial-assistance/ авах боломжтой бөгөөд эмнэлгийн бүртгэлийн хэсгээс хэвлэсэн хувийг үнэ төлбөргүйгээр авч болно. Мөн эдгээр бичиг баримтыг доор дурдсан дугаараар залгаж эсвэл шуудангаар хүлээн авч болно. Эдгээр бичиг баримтуудыг мөн Испани, Орос, Солонгос, Сири, Араб, Вьетнам, Польш, Монгол, Герман болон Япон хэл дээр авах боломжтой.

Үндэслэлтэй эрх бүхий биш бол хүсэлтийг (нэмэлт бичиг баримтын хамт) дор жагсаасан хаягаар шуудангаар эсвэл эмнэлгийн санхүүгийн зөвлөхөд аль болох богино хугацаанд, үйлчилгээний анхны төлбөрийн мэдүүлэг ирснээс хойш 240 хоногийн дотор ирүүлнэ.

Бөглөсөн хүсэлтийг хаашаа илгээх вэ:			
Эмнэлэг:	<u>Эванстон Эмнэлэг</u> <u>Гленбруук эмнэлэг</u> <u>Скоки эмнэлэг</u> <u>Хайлэнд парк эмнэлэг</u>	<u>Шведийн эмнэлэг</u>	<u>Нордвестийн олон нийтийн эмнэлэг</u>
Шуудан:	НордШоор Их сургуулийн Эрүүл мэндийн систем Өвчтөний санхүүгийн үйлчилгээний алба Шуудангийн хайрцаг 1006, Салбар 330 Скоки, Иллинойс 60076-9877	Шведийн эмнэлэг Санхүүгийн үйлчилгээний төв 5145 Хойд Калифорния өргөн чөлөө, Чикаго, Иллинойс 60625	Нордвестийн олон нийтийн эмнэлэг Өвчтөнд Үйлчлэх Төв Хэнд: Санхүүгийн зөвлөгөө 800 баруун төв зам Арлингтон Хайтс, Иллинойс 60005

Бөглөсөн хүсэлтийг хаашаа илгээх вэ:

<u>Факс:</u>	(847) 982-6957	(773) 878-3838	(847) 618-4549
<u>Тусламж хэрэгтэй юу?</u> <u>Бид тусалж чадна.</u>	(847) 570-5000 луу залгах эсвэл эмнэлгийн бүртгэлийн хэсэгт очиж, эмнэлгийн санхүүгийн зөвлөхтэй уулзаарай	(773) 989-3841 луу залгах эсвэл Санхүүгийн үйлчилгээний албанд очиж, эмнэлгийн санхүүгийн зөвлөхтэй уулзаарай	(847) 618-4542 луу залгах эсвэл Өвчтөнд үйлчлэх төвд очиж, эмнэлгийн санхүүгийн зөвлөхтэй уулзаарай